



БАТЛАВ
"ДАШМЯНГАН" ХХК-ИИН
ЗАХИРАА



БАРАА НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 04 дугээр
сарын 08 -ны едер

Дугаар: 002/2024

Нэг. Нийтлэг ундэслэл

1.1 Энэхүү гэрээг нэг талаас Завхан аймгийн Цаг уур, орчны шинжилгээний төв /цаашид захиалагч гэх/-ийг төлөөлж Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга Э.Мөнгөнцэцэг, негеэ талаас улсын бүртгэлийн регистр 2633809 дугаарт бүртгэлтэй "Дашмянган" ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/- ийг төлөөлж Б.Баасандаш нар дор дурьдсан нөхцлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг батлав.

1.2 Хур тунадас нэмэгдүүлэх зориулалттай газрын генераторын Техникийн үзүүлэлт хангасан тусгай зориулалтын түвш урвалжаар хангах

1.3 Нийлүүлэх барааны үнийн задаргаа, техникийн тодорхойлолт, төлбөр төлөх банкны мэдээллийг хавсаргав.

Хоёр. Захиалагчийн эрх, уурэг

2.1 Захиалагч нь бараа нийлүүлэх ажлын явцад шаардлага болон хяналт тавих эрхтэй.

2.2 Төлбөрийг энэхүү гэрээний 4.2-т заасны дагуу төлнө.

2.3 Цаг уурын салбарт хэрэглэгддэг тусгай зориулалтын хэрэгсэл тул шаардлагатайтохиолдолд тухайн барааг хэрэглэх, ашиглах, эзэмших заавар зөвлөмжийг шаардах эрхтэй.

2.4 Гүйцэтгэгч талаас тухайн онд үйлдвэрлэгдсэн, олон улсад худалдаалах патент бүхий түвш нийлүүлэхийг шаардах эрхтэй.

2.5 Барааны сав баглаа боодол лац зэргийг шалгаж хүлээж авах актыг үйлдэх үүрэг хүлээнэ.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

3.1 Гүйцэтгэгч нь 24 ширхэг буюу 2 хайрцаг түвш урвалжийг урьдчилгаа төлбөр хийснээс хойш ажлын 30 хоногийн дотор бүрэн хүлээлгэн өгнө.

3.2 Гүйцэтгэсэн ажлын ур дүн гэрээний шаардлагад нийцээгүй тохиолдолд гүйцэтгэгч өөрийн зардлаар уг догоолдлыг арилгана.

3.3 Гүйцэтгэсэн ажлын төлбөрийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу хугацаандаа төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.

3.4 Барааг энэхүү гэрээний хавсралтад заасны дагуу хулээлгэн өгнө.

3.5 Гүйцэтгэгч нь нийлүүлэх бараа материалыг Замын-Үүдийн гааль болон Улаанбаатар хотод ирснийг захиалагчид мэдэгдэж нэхэмжлэхийг хүргүүлнэ.

Дөрөв. Төлбөр тооцоо

4.1 Энэхүү гэрээнд заасан ажлыг хийж гүйцэтгэсний төлбөрт 1 ширхэг нь 825.000 төгрөгийн 24 ширхэг түвш урвалжийн үнэ нийт 19.800.000 /арван есөн сая найман зуун мянган төгрөг/-ийг ДАШМЯНГАН компанийн ХААН банкин дахь 5315606032 дугаар бүхий дансанд шилжүүлэх буюу төлнө.

4.2 Урьдчилгаа төлбөр 70% буюу 13.860.000 /арван гурван сая найман эзун жаран мянган төгрөг/ төлж захиалга баталгаажна. Улаанбаатар хотод бараа материал бүрэн орж ирж хулээлгэн өгсөнөөр үлдэгдэл 30% буюу 5.040.000 /таван сая дөчин мянган төгрөгийг бүрэн шилжүүлнэ.

4.3. Дээрх үнэнд БНХАУ доторх тээвэр, үнэлгээ, барааны стандарт хэмжил зүйн буртгэл гаалийн татвар, НӨАТ болон бусад татвар хураамж орсон болно.



Тав . Техникийн үзүүлэлт

Ноцоох урвалжийн техникийн еренхий үзүүлэлтүүд:


1. Ноцоох урвалжийн урт 398 мм
2. Ноцоох урвалжийн диаметр 46,0 мм
3. Ноцоох урвалжийн нийт жин 925 +20 грамм
4. Урвалжийн ноцох бодисны жин 535+5 грамм
5. Ноцоох урвалж дэх Иодот мөнгө (Agl)-ний агууламж >10 грамм
6. Иодот мөнгө (Agl)-ний 1грамм урвалжийн үйлчилгээ нь (-10°C-д> 1,03 × 1015)
7. Урвалжийн задралын микро радиус 0,01-0,05
8. Нэг ноцоох урвалжийн шаталтын хугацаа 6 мин <
9. Нэг урвалжийн шаталтын температур 1260°C
10. Иодот мөнгө /Agl/-ний урвалжийн үйлчлэх ашигтай температур -5°C...-50°C
11. Ноцоох урвалж дахь бодисын ууршилт 700°C ... 1000°C
12. Ноцоох урвалжийн шаталтын даралт 15 атм

Зургаа. Гэрээний хариуцлага

- 6.1 Захиалагчийн буруутай үйлдлээс шалтгаалж бараа нийлүүлэх хугацаа хойшилсон болон тоо хэмжээг өөрчилсөн /нэмэлт захиалга хамаарахгүй/ зэрэг үүдэн гарах хариуцлагыг захиалагч өөрөө хүлээнэ.
- 6.2 Гүйцэтгэгчээс шалтгаалан бараа нийлүүлэх хугацааг хожимдуулсан, тоо хэмжээ дутуу, чанаргүй бараа материал нийлүүлсэн зэрэг шалтгаанаас учирсан хохирол, хариуцлагыг гүйцэтгэгч хүлээнэ.
- 6.3 Гүйцэтгэгч гэрээнд заасан хугацаанд барааг нийлүүлээгүй тохиолдолд хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.1%-тай тэнцэх хэмжээний алданги бодно. Алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн дүнгийн 20%-иас хэтэрч үл болно.
- 6.4 Захиалагч гэрээнд заасан хугацаанд төлбөрийг шилжүүлээгүй тохиолдолд хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0.3%-тай тэнцэх хэмжээний алданги бодно. Алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн дүнгийн 20%-наас хэтэрч үл болно.
- 6.5 Талуудаас үл хамаарч давдагдашгүй хүчин болох дайн байлдаан, байгальн гамшигт онц аюултай үзэгдэл, цар taxal, улс хоорондын хилийн хориг тавих зэрэг нөхцөлд алданги үл бодно.

Долоо. Гэрээ хүчин төгөлдөр болох, маргаан шийдвэрлэх

- 7.1 Энэхуу гэрээ нь хоёр тал гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно.
- 7.2 Гэрээг 2 хувь үйлдэнэ. /хувиуд адил хүчинтэй/
- 7.3 Маргаан гарвал хоёр тал холбогдох хууль, тогтоомж, энэхүү гэрээг үндэслэн шийдвэрлэх ба эс тохиролцвол шүүхээр асуудлыг шийдвэрлүүлнэ.



ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

